



## ХАЙЛАХ БУЮУ "АЛТАЙН ЭЗЭД"-Д ӨРГӨХ ДУУ

КАМИМУРА АКИРА (Япон)

Тууль нь одоо ч хайлдаг туульчидтай, сонсдог сонсогчидтой, нийгэмд ямар нэг нөлөөтэй байгаагийн ховорхон жишээний нэг нь Алтайн урианхайн тууль болно. Нэртэй туульчид болох ах дүү Б.Авирмэд, Б.Уртнасан нар туулиа хуучин уламжлалаар нь хайлдаг төдийгүй зарим нэг айл тэднийг тогтмол урьж хэдэн хоногийн турш тууль сонсдог байна. Хэрэв өвөлд ханиад дэлгэрч хүүхдүүд их өвчилбөл хүмүүс туульчаар тууль хайлуулахыг хүсдэг. Ингэснээр өвчин зовлон арилж энх тунх амьдрах болно гэж Алтайн урианхайчууд үздэг.

Алтайн урианхайн туульсын нэг онцлог нь туулийг бүдүүн дуугаар хэлдэгт оршино. Үүнийг "хайлах" гэдэг. "Хайлах" нь "аялах", "дуулах"-аас хүчтэй бүдүүн хоолойгоор дуугардгаараа ялгаатай юм. "Хайлах" гэдэг үг монгол хэлэнд үйл үгийн хэлбэрээр байгаа боловч "тууль хайлах" нь "хай" гэдэг нэр үгнээс гаралтай. Учир нь Хакасууд туулиа "хай" гэдэг бөгөөд Уулын алтайчууд бас туулиа "кай" гэдэг. Хакасын "хай" нь "тууль"-иас гадна "хөөмий" гэдэг утгыг багтаадаг. Тиймээс Хакасын туульч туулийнхаа бадаг бүрийн эцэст хөөмийлдэг. Хакас болон Уулын Алтайн үндэстний туульчид бас туулиа бүдүүн дуугаар "хайлдаг".

"Хөөмэй" буюу "Хай" нь Тува, Хакаст маш түгээмэл Алтайн урианхайн "тууль хайлах"-ыг ч нарийн дуу гаргадаггүй бас нэгэн төрлийн "хөөмий" гэж үзэж болно. Доктор Цолоогийн надад хэлснээр бол өнөөгийн Уртнасан, Авирмэд нарын туульчдаас өмнөх үеийн Алтайн урианхайн зарим туульчид жишээлбэл Жилкэр, Буян нар туулиа хайлахдаа Хакасын туульч шиг хөөмийлдэг байсан гэнэ. Мөн "цуур"-ыг дуу гаргах зарчмын хувьд нэг ёсны "хөөмий" гэж үзэж болох юм. Цуурч бүдүүн дуугаа өөрийн хоолойгоор, нарийн дуугаа хөгжмөөсөө гаргадаг юм. Иймээс "хайлах", "хөөмий", "цуур"-ыг хөгжмийн нэгэн ижил төрөлд



багтаан үзэж болно.

Тус хөгжмийн төрөл нь Алтайн нурууны эргэн тойрны нутгуудад (тухайлбал Алтайн урианхай, Тува, Уулын Алтай, Хакас, Шор гэх мэт нутгуудад) түгээмэл бөгөөд "уулын эзэд", "газрын эзэд" гэсэн ойлголтууд ч дээрх нутгуудад нийтлэг байдаг. Алтайн урианхайн туулийг "Алтайн эздэд" өргөдөг бөгөөд "цуур"-ын дуу ч гэсэн "Алтайн эзэд"-ийг баярлуулдаг. Хакасын "газрын эзэд" мөн хөгжим дуу сонсоод баярладаг<sup>1</sup>. Өөрөөр хэлбэл "хайлах" буюу түүнтэй ойролцоо хөгжмийн төрөл бол ер бусын далдын эзэнтэй харилцах арга гэж ойлгож болно.

Тус илтгэлдээ би "хайлах" нь бүдүүн дуугаар "Алтайн эзэд"-тэй харилцдаг арга мөн бөгөөд "Алтайн нуруу"-ны эргэн тойрны нутагт ер нь иймэрхүү дуугаар хүн бус юмтай харилцдаг уламжлалтай гэдэг таамаглалыг дэвшүүлж байна.

## **Өнөөгийн тууль дахь буддын шашны нөлөө**

Гэвч өнөөгийн "хайлах" гэдэг үгээр илэрч байгаа ойлголт нь зөвхөн "Алтайн эзэд"-тэй холбоотой бус харин түүнд Буддын шашны нөлөө илэрхий байдаг. Туульч Б.Авирмэд надад "хайлах" гэдэг үгийг нь тодоор хэлэхийг ингэж нэрлэдэг гэж тодруулсан бөгөөд туулийг шашны судар номыг ойлгохгүй хар хүнд зориулсан судар гэж ойлгож болох ажээ. Бас туулийн баатар нь бурхан болсон бөгөөд ямар туулийг, ямар айлд, ямар үед хэлэх вэ гэдэг нь тусгай ном журамтай. Хэрвээ зохихгүй айлд туулиа хайлбал тэр айл болон туульчид өөрт нь муу болно. Жишээлбэл: "Талын хар бодон" нь "Гомбо" бурхан бөгөөд зовлонд их нэрвэгдэж ядарсан үед хэлүүлдэг. Энэ нь "Дорж Зодов" гэдэг номыг уншсантай тэнцдэг. "Аргил цагаан өвгөн", "Бөх алтан нударам"-ыг үр садгүй айлд үр хүүхэд төрүүлэхээр хэлдэг. "Улаан эзэн бодон" бол "Жамсран" бурхан мөн бөгөөд туулийг хүндэтгэн үздэг айлд хэлдэг.<sup>2</sup>

Алтайн урианхайн тууль дахь Буддын шашны иймэрхүү нөлөө нь нэлээн сүүлд, тухайлбал Богд хаант улсын үед орж ирсэн



байж магадгүй. 1913 онд "Алтайн урианхайн баруун амбаны хошуу" нь "Сайн заяат Дөрвөдийн баруун-гарын Үнэн Зоригт хан аймаг"-т харъяалагдсан Дөрвөдийн туульчдын ихэнх нь лам бөгөөд тууль хайлдаг байжээ. Мөн "Хан Харангуй" бол "Ямандаг" бурхан, "Дайны хүрэл" бол "Жамсран" бурхан... юм. Энэ таван баатрыг "Лхам" бурхан толгойлж явдаг<sup>3</sup> гэх мэт Буддын шашны онол Дөрвөдийн туульд илэрхий байсан. Алтайн урианхайчууд Дөрвөдөд байсан бичмэл туулиас дамжуулж тууль сурсан гэсэн мэдээ бас бий.<sup>4</sup> Тэгэхдээ туульдаа Буддын шашны нөлөөг оруулсан байж магадгүй. Бас тухайн үед Алтайн урианхайд Шавцагаан, түүний хүү Ачилдаа (1881-1959) гэдэг хоёр хүн гэртээ шашны ном заахын зэрэгцээ айлд уригдаж тууль хайлдаг байсан гэдэг.<sup>5</sup> Алтайн урианхайд лам мөртлөө тууль хайлдаг хүн угаасаа тэр хоёр л байсан гэнэ. Энэ хоёр туульч Алтайн урианхайн туульд буддын шашны нөлөөг оруулсан байж магадгүй.

Ертөнцийг тойрч Буддын шашны дайсныг дарж явдаг "Лхам" бурхны домог нь Алтайн урианхайчууд туульдаа Буддын шашны нөлөөг оруулах үндсийг тавьж өгсөн байж магадгүй. Яагаад гэвэл тус домог нь зуны цагийг ирүүлэхийн тулд өвлийг ялж дарах хэрэгтэй гэдэг балар эрт үеийн ойлголттой холбоотой бөгөөд Алтайн урианхайн тууль ч гэсэн мөн ийм ойлголтыг агуулдаг. Туулийг зуны сайхан цагт хэлж болдоггүй, цээртэй байдаг бөгөөд хатуу хэцүү өвөлд хүмүүс тууль хайлуулахыг хүсдэг нь ч үүнийг нотлож байна.

## Тууль ба "Алтайн эзэд"

Дөрвөд, Алтайн урианхайн туулийн уламжлал нь тууль хэлэх аргын хувьд ондоо байна. Дөрвөдийн туулийг "аялдаг", "дуулдаг" бол Алтайн урианхайн туулийг "хайлдаг". Энэ нь дээрх хоёр ястны тууль Буддын шашны нөлөөний хувьд хэдийгээр төстэй болсон ч өөр хөгжлийн замаар явж ирснийг үзүүлж байна. Ер нь тууль хэлдэг арга нь амархан хувирахгүй гэж хэлж болно. Алтайн урианхайчууд Дөрвөдийн туулийг сурахдаа тууль хэлдэг аргаа өөрчлөөгүй нь "Алтайн эзэд"-тэй харилцах тэдний харилцааны



мөн чанар өөрчлөгдөөгүй гэсэн хэрэг.

Алтайн урианхайн туульч туулиа хэлэхээс өмнө заавал "Алтай"-гаас магтаж "Алтайн эзэд"-ийг урьж туулиа сонсгодог. "Алтайн эзэд" хөгжим дуу сонсох дуртай. "Товшуур" (тууль хайлахдаа хөгжимддөг) гэдэг хөгжмийн зэмсэг яаж үүссэн тухай домог нь тууль болон "Алтайн эзэд"-ийг баярлуулсны хүчинд ан агнаж чадсан тухай өгүүлдэг.<sup>6</sup> Энэ нь хүмүүс байгалийг аргадаж өөрсдөдөө ээлтэй хандуулж чаддаг гэсэн үзлийн нэг жишээ юм.

Иймэрхүү ойлголт нь нийт хүн төрөлхтөнд нийтлэг боловч Алтайн нурууны орчин тойрон нутгийн хувьд "хөөмий", "хай" гэх мэт дууны тусгай төрлүүдтэй холбоотойгоороо онцлог юм.

Мөн "цуур" хөгжим нь товшуурынхтай төстэй домогтой:

Эрт урьдын цагт Ээвийн голын хөвөөнд нэг өнчин хүүхэд газар ухаж жимс ногоо олж иддэг байжээ. Тийнхүү нэгэн өдөр газар ухаж байтал нэг гоё хүүхэн (Алтайн эзэн) ирээд чи одоо газар малтахыг боль. Би чамд нэг мод өгье. Чи тэр модоор дуу гаргаж хоолоо олж ид гэжээ. Тэгээд Зараат гэдэг мод өгөөд явсан аж. Үүнээс цуур үүссэн байна.<sup>7</sup>

Бас нэг домог нь:

Хоёр хүн анд морджээ. Гэтэл ер ан тааралдсангүй, болжмор ч атугай алж идэж чадсангүй гэнэ. Тийнхүү хоолгүй болоод өлсөөд явж байж. Тэр хоёр хүний нэг нь далдын юм үздэг, нөгөө нь юм үздэггүй харин цуур үлээдэг хүн байсан байна. Гэтэл нэг орой юм үздэг хүн хэлжээ: "Чи цуураа үлээ. Маргааш ан алагдаж магадгүй" гэжээ. Тэгээд тэр орой цуураа үлээжээ.

Ингээд Алтайгаа магтаж байтал Алтайн эзэн савдгууд бүгдээрээ тэр хүнийг шавж суужээ. Тэр үед Алтайн нэг эзэн багталцахгүй, цуур үлээгч хүний хамар дээр нь сууж байгаад хальтирсан байна. Үүнийг хараад далдын юм үздэг хүн инээжээ. Гэтэл цуур үлээж байсан хүн уурлаад үлээхээ больчихож гэнэ. Алтайн эздийн толгойлогч хальтирсан тэр нэгэнд чамаас болж Алтайн магтаал сонсож чадсангүй, Чиний ганц дайртай хар бугыг эдэнд өгнө гэжээ.

Маргааш өглөө тэр хоёр анд яваад нэг том буга алжээ. Тэр



ны унаж байсан учир дайртай байжээ. Ингээд "Алтайн урам" гэж дэлхийд цуурдсан байна.<sup>8</sup>

Энэ хоёр домог нь "цуур"-ын дуу туультай мөн адилхан "Алтайн эзэд"-тэй холбоотой гэдгийг өгүүлж байна.

## **"Хайлах" ба бусад хөгжмийн төрлүүд**

Японы хөгжим судлаач Проф.Оохаши "хөөмий" болон "цуур"-ын дуунд хүнд сонсогддоггүй нарийн долгион багтдаг бөгөөд тэр нарийн долгион хүний тархинд тусгай нөлөө өгдөг гэдгийг баталсан юм. Бөөгийн хэрэглэл болох аман хуурын дуу мөн тиймэрхүү нарийн долгионтой. Тиймээс онгод ороход амархан болдог байна.

Нэртэй цуурч Наранцогт гуай уулын орой дээр цуур үлээхдээ "Алтайн эзэн"-ийг хардаг гэнэ. Тэд нар янз бүрийн дүрстэй. Зарим нь морьтой ногоон дээлтэй залуу, зарим нь адгуус байдаг. Энэ бол "цуур" нь маш хүчтэй хөгжмийн зэмсэг гэдгийг өгүүлж байгаа хэрэг.

Мэдээж "далдын эзэн", "онгод" хүний сэтгэлийн гадна байдаггүй, харин түүний дотор оршдог. Бөө өөрийн сэтгэлийн дотор нойрсож байсан өөр хүнийг босгож дууддаг. Тэр нь "онгон". Наранцогт гуай өөрийн сэтгэлийн дотор л "Алтайн эзэн"-ийг үздэг бололтой.

Аман хуур, цуур, "хай" буюу туулийн дуу, хөөмий бүгд хүний сэтгэлийн гүнд орж чаддаг.

Хөөмийг заримдаа нялх хүүхдэд болон адгуус амьтанд сонсгодог. Учир нь нялх хүүхэд бол бүрмөсөн хүн болоогүй, хэзээ ч чөтгөр аваад явж магадгүй, хагас хүн, хагас хүн бус амьтан байдаг. Мөн дээр үеийн Алтайн урианхайн анчид хөөмийлөн ан амьтныг сатааруулан зогсоож агнадаг байсан гэнэ. Иймээс хөөмий нь хүн хүнтэйгээ бус харин хүнээс хүний хэл ойлгодоггүй амьтантай харилцах арга болон бүтээгдсэн байж магадгүй. Ер нь хүнд адгуус амьтантай төсөөтэй сэтгэхүй байдаг гэдэгт анхаарал тавих ёстой.



## Төгсгөл

"Хайлах" гэдэгт дээр хэлснээр "хөөмийлөх"-ийг бас багтааж болно. Гэвч "тууль хайлах" нь хүний дүрстэй хүний хэл ойлгодог далдын юманд зориулагддаг бол "хөөмий" нь хүн бус хүний хэл ойлгодоггүй нялх хүүхэд, амьтанд зориулагддаг байна. Харин "цуур"-ыг нэг ёсондоо хөгжмийн зэмсэгтэй "хөөмий" гэж ойлгож болох бөгөөд туультай адилхан "Алтайн эзэд"-эд зориулагддаг байна.

"Хайлах" нь бүдүүн дуугаар ер бусын юмтай харилцдаг арга гэсэн таамаглалыг бүрэн баталж чадахгүй боловч энэ талаар өөрийн олсон цөөн материалыг үзээд дээр дурдсан дүгнэлтийг хийлээ. Алтай нурууны эргэн тойрон нутгуудын хөгжмийн төрөл зэмсгүүдийн хувьд олж ашиглаж чадах материал цөөн учраас бараг үзэж чадаагүй билээ.

Алтайн урианхайн туулийг зөвхөн нэг улс, нэг үндэстэн эсвэл шинжлэх ухааны нэг салбарын хүрээнд авч үзэх боломжгүй нь тодорхой учир цаашид илүү гүн гүнзгий судалгаа шаардлагатай байгаа болно.

Ингээд тус симпозиумийн цаашдын үйл ажиллагаа улам өргөн хүрээтэй байгаасай гэж хүсэж байна.

## Зүүлт

1. См. "Хакасы" в Народы России, 1992, М
2. Нарантуяа, 1975
3. Цолоо, 1967
4. Нарантуяа, 1975
5. Recorded by author from Sodov in Bulgan sum, Bayan-Olgii aimag on Jun 29, 1996.
6. 51-52-р хуудсанд, Туяабаатар, 1995
7. Recorded by author from Narantsogt in Duut sum, Hovd aimag on Aug 5, 1995.
8. Recorded by author from Narantsogt in Duut sum, Hovd aimag on Aug 6, 1995.



## **Ашигласан материал**

Нарантуяа Р. 1975, **Ховд, Баян-Өлгий аймагт явсан эрдэм шинжилгээний ангийн тайлан**, Монгол улсын ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиолын хөмрөг х.5 тн.48

Цолоо Ж. 1967, **Ховд, Баян-Өлгий аймагт явсан эрдэм шинжилгээний ангийн тайлан**, Монгол улсын ШУА-ын Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиолын хөмрөг х.5 тд.12 хн.7

**Алтайн урианхайн аман зохиолын цоморлиг**, 1990, Өлгий Арван гурван хүлгийн дуун, 1987, УБ

Бадамхатан С, Лхагвасүрэн И. 1996, **Алтайн урианхай, Монгол улсын угсаатны зүй 2 боть**, Ойрадын угсаатны зүй УБ

Getty A. 1988 (reprint), **The Gods of Northern Buddhism**, Dover Hamayon R. 1991, **La Chasse d'une Ame**, Nanteer **Народы России**, 1992, М

Туяабаатар Лха. 1995, **Алтайн урианхайн баатарлагийн туульс, түүний эх сурвалж өвөрмөц шинж**, Өлгий.

Золбаяр Г. 1996, **Тува-малчин, Монголын угсаатны зүй 3 боть**, УБ.